

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/284/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитор: Т.Нямсүрэн Утас: 260512 Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн захирал: Б.Пүрэвдулам Утас: 70005711 Цахим хаяг: dulguunkhairkhanuulaudit09@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	19
4.1 Ерөнхий зүйл .....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	22
5.1 Төлбөрийн акт .....	22
5.2 Албан шаардлага .....	23
5.3 Зөвлөмж .....	24
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	25
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	25
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	26
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	28

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ТЕАТРЫН  
ДАРГА Н.АРИУНБОЛД ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.05 № 06/450  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хүүхэд залуучуудын театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 18,931,058.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Ажилтанд цалин, амралтын мөнгө 1,488.4 мянган төгрөг илүү олгосон;
- Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар бий болсон 18,929,570.2 мянган төгрөгийн барилга байгууламжийг санхүүгийн тайланд бүртгэж аваагүй;
- Утга агуулга ижил 88,742.4 мянган төгрөгийн гэрээ байгуулан батлагдсан төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 158 дугаар тогтоолоор Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтад орсон 850 хүний суудалтай театрын шинэ барилгыг улсын комисс хүлээн авч, Хүүхэд, залуучуудын театрт хүлээлгэн өгснөөс хойш тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, 2025 онд шинээр гурван жүжиг хоёр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 250,000.0 мянган төгрөг, байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 539,102.6 мянган төгрөг, нийт 789,102.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 345,702.5 мянган төгрөгийг зарцуулж, нийт 443,400.1 мянган төгрөгийг төвлөрүүлснээс 443,250.1 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

## **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б. Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>639,950,267.86</b>	<b>993,250,067.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>53,190,159.36</b>	<b>443,559,600.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,803,159.36	-
33101	Цалингийн авлага	2,326,147.78	-
33103	ХАОАТ-ын авлага	477,011.58	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	50,387,000.00	443,250,100.00
33401	Дансны авлага (ТӨҮГ)	-	309,500.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>6,000,000.00</b>	-
34600	Урьдчилж гарсан зардал	6,000,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>580,760,108.50</b>	<b>549,690,467.00</b>
35100	Түүхий эд материал	72,000.00	645,400.00
35130	Эм боох материал	72,000.00	645,400.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	47,135,900.00	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	101,758,040.00	123,467,888.00
35400	Хангамжийн материал	431,794,168.50	425,577,179.00
35410	Бичиг хэргийн материал	5,797,440.00	6,224,580.00
35420	Аж ахуйн материал	53,170,831.50	55,310,749.00
35430	Сэлбэг хэрэгсэл	141,450.00	620,050.00
35450	Барилгын засварын материал	82,947,000.00	240,000.00
35470	Бусад хангамжийн материал	289,737,447.00	363,181,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,014,707,342.72</b>	<b>4,472,408,623.10</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,014,707,342.72</b>	<b>4,472,408,623.10</b>
39200	Биет хөрөнгө	5,014,707,342.72	4,472,408,623.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	28,000,000.00	28,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(777,777.80)	(2,644,444.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,120,000.00	119,120,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(8,155,000.01)	(20,067,000.05)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,894,016,895.00	3,939,046,895.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(299,799,077.93)	(876,845,730.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,449,243,752.50	1,563,264,752.50
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(179,941,449.04)	(360,039,245.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	73,398,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	-	(4,225,103.88)
39217	Номын фонд	13,000,000.00	13,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (3=1+2)</b>	<b>5,654,657,610.58</b>	<b>5,465,658,690.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>469,887.78</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>469,887.78</b>	-
41300	Өглөг	469,887.78	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	466,887.78	-
41312	НДШ-ийн өглөг	466,887.78	-
41360	Бусад өглөг	3,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,654,187,722.80</b>	<b>5,465,658,690.10</b>
<b>51</b>	<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО</b>	<b>5,654,187,722.80</b>	<b>5,465,658,690.10</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	5,654,187,722.80	5,465,658,690.10
51210	Өмнөх үеийн үр дүн	1,613,321,457.22	5,654,187,722.80
51220	Тайлант үеийн үр дүн	4,040,866,265.58	(188,529,032.70)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (6=4+5)</b>	<b>5,654,657,610.58</b>	<b>5,465,658,690.10</b>

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>7,684,971,899.99</b>	<b>4,420,021,030.79</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,653,088,420.00</b>	<b>693,505,930.79</b>
120	Нийтлэг татварын бус орлого	4,653,088,420.00	693,505,930.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	281,388,500.00	442,457,600.00
120004	Үндсэн үйл ажиллагааны орлого	204,988,500.00	230,324,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	76,400,000.00	212,133,600.00
120005	Түрээсийн орлого	28,125,000.00	46,570,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,039,269,960.00	157,669,230.79
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	304,304,960.00	46,808,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,031,883,479.99</b>	<b>3,726,515,100.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,709,484,100.00	3,476,515,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,709,484,100.00	3,476,515,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	322,399,379.99	250,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	322,399,379.99	250,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,644,105,634.41</b>	<b>4,608,550,063.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,644,105,634.41</b>	<b>4,608,550,063.49</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,266,598,786.16	<b>4,348,390,637.34</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,660,458,311.61	2,350,555,440.59
210101	Үндсэн цалин	1,181,929,256.89	1,510,831,138.85
210102	Нэмэгдэл	193,056,990.32	334,801,378.50
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	177,740,000.00	282,533,296.56
210104	Урамшуулал	107,732,064.40	222,389,626.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209,470,839.15	303,756,031.68
210201	Тэтгэврийн даатгал	141,658,573.97	213,189,167.15
210202	Тэтгэмжийн даатгал	16,645,894.51	24,743,471.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,976,880.77	13,419,520.88
210204	Ажилгүйдлийн даатгал	8,237,897.90	10,480,773.16
210205	Эрүүл мэндийн даатгал	32,951,592.00	41,923,099.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,479,409.81	90,134,905.76
210301	Гэрэл, цахилгаан	34,426,236.72	47,730,426.86
210302	Түлш, халаалт	15,153,291.51	33,249,079.90
210303	Цэвэр, бохир ус	5,219,881.58	9,155,399.00
210304	Байрны түрээс	11,680,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	84,231,775.30	168,069,067.75
210401	Бичиг хэрэг	4,352,401.53	7,889,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,215,300.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,399,705.27	4,345,007.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,328,778.50	37,764,082.50
210408	Бараа материал акталсны зардал	14,935,590.00	-
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	115,920,077.85
2105	Норматив зардал	427,150.00	677,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	427,150.00	677,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,438,000.00	138,000,570.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	54,953,570.00

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	31,438,000.00	83,047,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	750,856,184.32	386,194,282.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	747,447,664.32	385,595,282.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	421,020.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	599,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	47,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	463,237,115.97	911,002,589.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,243,564.47	128,795,217.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	361,993,551.50	782,207,372.56
212	ТАТААС	11,250,000.00	19,456,200.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	11,250,000.00	19,456,200.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	11,250,000.00	19,456,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	366,256,848.25	240,703,226.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,500,000.00	39,320,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	39,320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	131,500,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	234,756,848.25	201,383,226.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	234,756,848.25	201,383,226.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3=1-2)</b>	<b>4,040,866,265.58</b>	<b>(188,529,032.70)</b>
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6=3+4-5)</b>	<b>4,040,866,265.58</b>	<b>(188,529,032.70)</b>

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,318,914,579.99</b>	<b>4,265,617,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>287,031,100.00</b>	<b>539,102,600.00</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	287,031,100.00	539,102,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	258,906,100.00	492,532,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	182,506,100.00	252,498,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	76,400,000.00	240,033,600.00
120005	Түрээсийн орлого	28,125,000.00	46,570,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,031,883,479.99</b>	<b>3,726,515,100.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,709,484,100.00	3,476,515,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,709,484,100.00	3,476,515,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	322,399,379.99	250,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	322,399,379.99	250,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,307,664,579.99</b>	<b>4,265,617,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,307,664,579.99</b>	<b>4,265,617,700.00</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,891,020,731.74	3,581,664,373.85
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,658,768,685.12	2,347,276,067.20
210101	Үндсэн цалин	1,187,718,414.65	1,500,120,655.26
210102	Нэмэгдэл	191,927,007.65	334,171,738.70
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	177,133,597.06	291,003,546.56
210104	Урамшуулал	101,989,665.76	221,980,126.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	213,496,737.22	304,699,133.49
210201	Тэтгэврийн даатгал	145,528,752.04	213,949,924.44
210202	Тэтгэмжийн даатгал	16,682,124.51	24,756,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,956,930.77	18,052,256.45
210204	Ажилгүйдлийн даатгал	8,297,677.90	9,981,536.70
210205	Эрүүл мэндийн даатгал	33,031,252.00	37,958,515.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,479,409.81	109,591,105.76
210301	Гэрэл, цахилгаан	34,426,236.72	47,730,426.86
210302	Түлш, халаалт	15,153,291.51	33,249,079.90
210303	Цэвэр, бохир ус	5,219,881.58	9,155,399.00
210304	Байрны түрээс	11,680,000.00	19,456,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	104,265,565.27	13,068,247.40
210401	Бичиг хэрэг	4,143,440.00	1,670,890.00
210402	Тээвэр, шатахуун	13,455,300.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,399,705.27	4,345,007.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	84,267,120.00	4,902,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	253,062,900.00	102,917,570.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	224,461,900.00	102,917,570.00
210602	Тавилга	28,601,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	580,118,884.32	644,801,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	575,612,864.32	644,202,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	421,020.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	599,000.00

**Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,145,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,828,550.00	59,310,570.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,828,550.00	59,310,570.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	416,643,848.25	683,953,326.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,500,000.00	39,320,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	39,320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	131,500,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	285,143,848.25	644,633,326.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	234,556,811.06	201,233,226.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	50,587,037.19	443,400,100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3=1-2)</b>	<b>11,250,000.00</b>	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>11,250,000.00</b>	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,250,000.00	-
22300	Бусад хөрөнгө	11,250,000.00	
223001	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн - ТӨҮГ	11,250,000.00	
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	<b>(11,250,000.00)</b>	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8=3+6+7)</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,613,321,457.22</b>	<b>1,613,321,457.22</b>
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>1,613,321,457.22</b>	<b>1,613,321,457.22</b>
9	Тайлант үеийн үр дүн	-	-	4,040,866,265.58	4,040,866,265.58
<b>10</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>5,654,187,722.80</b>	<b>5,654,187,722.80</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	5,654,187,722.80	5,654,187,722.80
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(188,529,032.70)	(188,529,032.70)
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>5,465,658,690.10</b>	<b>5,465,658,690.10</b>

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>3,513,262,800.00</b>	<b>3,275,281,873.85</b>	<b>237,968,326.15</b>	<b>93.2</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>3,513,262,800.00</b>	<b>3,275,281,873.85</b>	<b>237,968,326.15</b>	<b>93.2</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,513,262,800.00</b>	<b>3,275,281,873.85</b>	<b>237,968,326.15</b>	<b>93.2</b>
<b>122005</b>	<b>Төсвөөс санхүүжих</b>	<b>3,513,262,800.00</b>	<b>3,275,281,873.85</b>	<b>237,968,326.15</b>	<b>93.2</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,513,262,800.00</b>	<b>3,275,281,873.85</b>	<b>237,968,326.15</b>	<b>93.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,513,262,800.00</b>	<b>3,275,281,873.85</b>	<b>237,968,326.15</b>	<b>93.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,473,937,500.00</b>	<b>3,235,961,873.85</b>	<b>237,963,026.15</b>	<b>93.2</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,507,679,800.00</b>	<b>2,347,276,067.20</b>	<b>160,391,132.80</b>	<b>93.6</b>
210101	Үндсэн цалин	1,654,455,900.00	1,500,120,655.26	154,322,644.74	90.7
210102	Нэмэгдэл	272,591,500.00	334,171,738.70	(61,580,238.70)	122.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	374,433,800.00	291,003,546.56	83,417,653.44	77.7
210104	Урамшуулал	206,211,200.00	221,980,126.68	(15,768,926.68)	107.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>313,806,100.00</b>	<b>304,699,133.49</b>	<b>9,106,966.51</b>	<b>97.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	214,794,500.00	213,949,924.44	844,575.56	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	24,756,900.00	24,756,900.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,468,300.00	18,052,256.45	(5,583,956.45)	144.8
210204	Ажилгүйдлийн даатгал	12,357,200.00	9,981,536.70	2,375,663.30	80.8
210205	Эрүүл мэндийн даатгал	49,429,200.00	37,958,515.90	11,470,684.10	76.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>119,616,200.00</b>	<b>87,881,905.76</b>	<b>31,734,294.24</b>	<b>73.5</b>
210301	Гэрэл, цахилгаан	43,155,100.00	45,477,426.86	(2,322,326.86)	105.4
210302	Түлш, халаалт	62,830,500.00	33,249,079.90	29,581,420.10	52.9
210303	Цэвэр, бохир ус	13,630,600.00	9,155,399.00	4,475,201.00	67.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,861,100.00</b>	<b>12,118,247.40</b>	<b>4,742,852.60</b>	<b>71.9</b>
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00	-	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,579,700.00	4,345,007.40	4,234,692.60	50.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,990,900.00	4,902,350.00	88,550.00	98.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>104,867,500.00</b>	<b>102,917,570.00</b>	<b>1,949,930.00</b>	<b>98.1</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	104,867,500.00	102,917,570.00	1,949,930.00	98.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>328,368,800.00</b>	<b>321,758,380.00</b>	<b>6,610,420.00</b>	<b>98.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	321,159,400.00	321,159,380.00	20.00	100

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	-	4,977,100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	437,600.00	-	437,600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,794,700.00	599,000.00	1,195,700.00	33.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>82,738,000.00</b>	<b>59,310,570.00</b>	<b>23,427,430.00</b>	<b>71.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,738,000.00	59,310,570.00	23,427,430.00	71.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,325,300.00</b>	<b>39,320,000.00</b>	<b>5,300.00</b>	<b>100</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,325,300.00	39,320,000.00	5,300.00	100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,325,300.00	39,320,000.00	5,300.00	100
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>110</b>	<b>99</b>	<b>11</b>	<b>90.0</b>
620001	Удирдах ажилтан	4	3	1	75.0
620002	Гүйцэтгэх ажилтан	72	69	3	95.8
620003	Үйлчлэх ажилтан	34	27	7	79.4

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Тайлант он
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>769,646,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>769,646,400.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>769,646,400.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>769,646,400.00</b>
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	769,646,400.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000,000.00
<b>350015</b>	<b>Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого</b>	<b>519,646,400.00</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>326,246,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>326,246,300.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,246,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,253,000.00</b>
<b>210301</b>	<b>Гэрэл, цахилгаан</b>	<b>2,253,000.00</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	950,000.00
<b>210405</b>	<b>Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал</b>	<b>950,000.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>323,043,300.00</b>
<b>210801</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>323,043,300.00</b>
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>443,400,100.00</b>
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(443,400,100.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(443,400,100.00)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхэд залуучуудын театр нь хүүхэд залуучуудын насны онцлогт тохирсон соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Хүүхэд, залуучуудын театрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд, залуучуудын нас сэтгэхүйн онцлогт тохирсон үндэсний, сонгодог, орчин үеийн уран бүтээлээр үйлчлэх;
- Хүүхэд, залуучуудын гоо зүй, авьяас чадвар, танин мэдэхүйн боловсролыг дээшлүүлэх тайзны урлагийн олон талт хэлбэрийн уран бүтээл хийх, олон нийтийн хүртээл болгох;
- Хүүхэд, залуучуудад зориулан урлагийн боловсрол олгох зорилгоор тодорхой хугацаанд ашиглуулах зориулалтаар сан хөмрөг бүхий мэдээлэл үйлчилгээг үзүүлэх номын сангаар үйлчлэх;
- Театр нь урын сангийн бодлогыг тасралтгүйгээр хөгжүүлэх, уран бүтээлчдийг сургаж дадлагажуулах.

Хүүхэд, залуучуудын театрыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 158 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан, 850 хүний суудалтай театрын шинэ барилгыг 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдөр улсын комисс ашиглалтад авч, Хүүхэд залуучуудын театрт хүлээлгэн өгсөн байна.

Театрын бүтэц, орон тоог Соёлын сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар 4 хэлтэс, 110 хүний орон тоотойгоор баталсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүүхэд, залуучуудын театр нь дараах хууль эрх зүйн орчны хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Соёлын тухай хууль,
- Соёлын өвийг хамгаалах хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай /Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол/,
- ТБОНӨХБАҮХА ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ тогтоох тухай /Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол/.

Тайлант хугацаанд театрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 3 дугаар тогтоол,

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”,
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”,
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”.

Хүүхэд, залуучуудын театр удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус театр нь дотоод аудитын нэгж, ажилтангүй. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар дотоод аудитыг хийдэг бөгөөд тайлант хугацаанд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүнийг гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхэд, залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүүхэд, залуучуудын театр нь Соёлын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн загвараар холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт, тохирсон бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүүхэд, залуучуудын театр нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 188,529.0 мянган төгрөгөөр буюу 3.5 хувь буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	53,190.2	443,559.6	390,369.4
Урьдчилгаа	6,000.0	-	(6,000.0)
Бараа материал	580,760.1	549,690.5	(31,069.6)

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө	5,014,707.3	4,472,408.6	(542,298.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,654,657.6</b>	<b>5,465,658.7</b>	<b>(188,998.9)</b>
Өр төлбөр	469.9	-	(469.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,654,187.7	5,465,658.7	(188,529.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,654,657.6</b>	<b>5,465,658.7</b>	<b>(188,998.9)</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Авлага дансны үлдэгдэл 443,559.6 мянган төгрөг болж, 390,369.4 мянган төгрөгөөр өссөн байна. Авлагын үлдэгдэл нэмэлт санхүүжилтийн авлага 443,250.1 мянган төгрөг, бусад төрийн байгууллагаас авах авлага 309.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл хаагдаж өмнөх оноос 6,000.0 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх онд театрын нээлтийн ажиллагаанд тоглогдох 2 жүжгийн хувцас, тайзны засал, хөгжмийн найруулгын бэлтгэл, дуу бичлэгийн зардал, номын сангийн номны зардал болон бусад бараа материал худалдан авахад гарсан зардлуудыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 549,960.5 мянган төгрөг болж, 31,069.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд дуусаагүй үйлдвэрлэл дансны 47,135.9 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 46,808.6 мянган төгрөгийн бараа материалыг дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авч, 168,069.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, нийт 198,811.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,472,408.6 мянган төгрөг болж, 542,298.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд 47,135.9 мянган төгрөгийн хөрөнгө дуусаагүй үйлдвэрлэл данснаас, 116,868.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 157,669.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Мөн балансаас балансад 120,854.7 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн. Тайлант хугацаанд 415,109.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 469.9 мянган төгрөгөөр буурсан байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр 466.9 мянган төгрөг, бусдад өгөх өглөг 3.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,465,658.7 мянган төгрөг болж, 188,529.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Программ хангамжийн талаар “Ординат” ХХК-ийн Unicus 1.1 программ ашиглаж байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,473,937.5 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 39,325.3 мянган төгрөг, нийт зарлагыг 3,513,262.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,513,262.8 мянган төгрөгийн төсөв батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,476,515.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 3,275,281.9 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 201,233.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 237,968,3 мянган төгрөгөөр дутуу буюу 93.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 160,391.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 9,107.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 31,734.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 4,742.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 6,610.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,949.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 23,427.4 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 5.3 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702	Соёл урлаг	3,513,262.8	3,275,281.9	237,968.3	93.2
1.1	80801	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,079,094.1	2,717,426.5	361,847.6	88.3
1.2	80214	Уран бүтээл хийлгэх	100,000.0	249,159.3	(149,159.3)	249.1
1.3	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх	72,000.0	72,000.0	-	100.0
1.4	81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	262,168.7	236,876.1	25,292.5	90.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Соёл, спорт, аялал, жуучлал, залуучуудын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 01/2515 дугаартай албан бичгээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу орон тоог 110 байсныг 9 хувиар бууруулж, 99 ажилтны орон тоотой ажиллаж байна.
2. Монгол улсын засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ыг 8.2, 8.4, Хөдөлмөрийн дотоод журмын 4.4.22-ыг тус тус үндэслэн нэг өдрийн албан хаагчдын ажилдаа ирэх буцах нийтийн тээврийн унааны зардлыг өдрийн 2.0 мянган төгрөг, хоолны зардлыг 11.5 мянган төгрөг байхаар шинэчлэн баталж, тайлант хугацаанд унаа хоолны зардалд 374,433.8 мянган төгрөг төлөвлөн 291,003.5 мянган төгрөг зарцуулсан байна.
3. Гадаад албан томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал байхгүй.
4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал байхгүй.

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, зардал гараагүй.
6. Тайлант хугацаанд хамаарах төрд учирсан хохирол байхгүй.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрт төсвийн захирагчийн төсөл хөтөлбөрийн 250,000.0 мянган төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 519,646.6 мянган төгрөг, нийт 769,646.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2,253.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 950.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 323,043.3 мянган төгрөг, нийт 326,246.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 443,400.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс 443,250.1 мянган төгрөгийг буцаан авахаар тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Нийт 2 хөтөлбөр, арга хэмжээнд 370,000.0 мянган төгрөг зарцуулахаас 370,000.0 мянган төгрөгийг зарцуулж, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Ромео Жульетта	2025.05.09		100.0	350,000.0	50,000.0
2	Хүүхнүүдийн хаанчлал	2025.03.08		100.0	20,000.0	20,000.0
<b>Нийт дүн</b>				<b>100.0</b>	<b>370,000.0</b>	<b>370,000.0</b>

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд урсгал төсвөөс нийт 372,515.2 мянган төгрөгийн 29 нэр бүхий бараа, ажил, үйлчилгээг театрын үйл ажиллагааг зохион байгуулах болон байгууллагын үйл ажиллагаанд зориулан худалдан авахаар тусгаж, гүйцэтгэлээр харьцуулалтын босго үнийн дүнгээс бага нийт 372,515.2 мянган төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүүхэд, залуучуудын театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Хүүхэд, залуучуудын театр түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дөлгөөнхайрхан уул аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Янжмаа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер С.Долгорсүрэн, захирал Б.Пүрэвдулам нар, дараагийн шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Нямсүрэн, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын 3,694,492.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 36,944.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2025 оны нийт зардлын 4,608,550.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 46,085.5 мянган төгрөгөөр дахин шинэчлэн тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан ба төсвийн хэтрэлт гаргаагүй байна

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2 зөрчилд зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 167 мэдээлэл мэдээлэхээс байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1 мэдээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 1 нийт 2 мэдээ хугацаа хоцорч мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулдаггүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хугацаандаа байршуулаагүй тул холбогдох хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хүүхэд, залуучуудын театр нь Соёлын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн загвараар холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт, тохирсон бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, мөн дээрх бодлогыг тухайн байгууллагын ерөнхий нягтлан бодогч хуулийн этгээд боловсруулах ёстойг дараах байдлаар хуульчилсан болно”, 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагаас төсөв зарцуулахгүйгээр өөрсдийн нөөц боломжоор байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн данстуудын хувьд горим, сорил хэрэгжүүлж, аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 53,135.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 447,959.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийг зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах 4,750.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийн биелэлт 60.0 хувь байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	447,959.4	1	411,959.4	50.0
Зөвлөмж	2	4,750.0	1	4,750.0	70.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>452,709.4</b>	<b>2</b>	<b>416,709.4</b>	<b>60.0</b>

Театрын барилгыг хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байгаа ч барилга, байгууламжийг үндсэн хөрөнгөд бүртгэж, санхүүгийн тайланд тусгаагүй өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. Байгууллага 2025 оны 10 дугаар сараас цагийн бүртгэлийн систем шинээр нэвтрүүлсэн боловч программын алдаатай ажиллагаа болон ажилчид цагийн бүртгэлд бүртгүүлж бүрэн хэвшээгүй байгаатай холбоотой 2025 оны 10, 11, 12 дугаар сарын цалинг хуучин гараар бүртгэж байсан аргаар тооцон цалингийн тооцоолол хийсэн байна. Дараагийн аудитаар программын үйл ажиллагааг сайжруулан цагийн бүртгэл болон цалингийн тооцоололд тавих хяналтыг сайжруулсан эсэхийг авч үзэх.
2. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмыг байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлд бүрэн нэвтрүүлэн, санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлэн үнэн зөв бэлтгэхэд анхаарч ажиллах, уг журмын гуравдугаар хавсралтаар баталсан "Дансны жишиг жагсаалт"-ыг дагаж мөрдөн сайжруулсан эсэхийг авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **53,135.9** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Театрын нээлтийн ажиллагаатай холбоотой 2023 оноос урьдчилж төлсөн зардал дансанд үлдсэн урьдчилгаа 6,000.0 мянган төгрөгийг анхан шатны баримтыг үндэслэж, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” заалттай нийцээгүй, УСНББОУС-1, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй,
- Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 47,135.9 мянган төгрөгийн дүнд биет тооллого хийхэд тухайн үлдэгдэл нь оёдол хийж дууссан жүжгийн хувцас байх тул тайлант хугацаанд уг хөрөнгийг дуусаагүй үйлдвэрлэл данснаас хасаж хөрөнгө, бараа материалын дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй.

Аудитаар нийт 19,019,801.0 мянган төгрөгийн 7 зөрчил илэрсэнд 1,488.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 19,018,312.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 19,019,801.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 18,973,715.5 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

#### 5.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Өмнөх оны ээлжийн амралтыг 2024 оны 7 сард авсан ба хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон Э.Алзахгүйд захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар ээлжийн амралтыг бүтэн хоногоор буюу 15 хоногоор тооцож, 718.6 мянган төгрөг, оёдолчин албан тушаалтай Д.Жавхааг ТҮСБ-02 ангиллаар цалинг тогтоосон боловч ТҮСБ-3 ангиллаар цалинг бодож, 769.8 мянган төгрөг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгоогүй, 718.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон ба ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийгээгүй, оёдолчинд ТҮСБ-02 ангиллаар цалинг тооцохоор тогтоосон боловч ТҮСБ-3 ангиллаар цалинг бодож, 769.8 мянган төгрөгийг илүү олгосон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

### 5.2.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Тайлант онд жүжгийн хувцас хэрэгслийн материалыг авахдаа утга агуулга ижил 7 гэрээг байгуулж худалдан авалт хийж, гүйцэтгэгчийг сонгохдоо шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж 88,742.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

### 5.2.2 Хөрөнгийн данстай холбоотой асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар бий болсон төрийн болон аймаг, нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт" 704 дүгээр тогтоолоор 850 хүний суудалтай театрын шинэ барилгыг орлогод авч бүртгэлд тусгах шийдвэр ирүүлсэн боловч барилгын газрыг Сонгинохайрхан дүүргийн Тамгын газраас шилжүүлэн аваагүй, түүнийг шилжүүлэн авахтай холбоотой газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны төлбөр төлөх санхүүжилтгүй гэх шалтгаанаар барилга байгууламжийг санхүүгийн тайланд бүртгэж аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйл, Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах гэсний Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэл хөтлөх гэсний 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн хуулийн заалт болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар бий болсон төрийн болон аймаг, нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт" 704 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Театрын барилга, байгууламжийг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу данс бүртгэлд тусгаж, хөрөнгийн бүртгэлд тавих хяналтыг хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

### 5.2.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

Жолоочийн тооцооны хуудсыг 2025 оны 1-4 дүгээр сард хөтөлсөн ба түүнээс хойш жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, шатахууны зардлын санхүүжилт байхгүй гэх боловч машинууд дээр торгуулийн хуудас сар бүр бичигдсэн, засварын зардал бүртгэсэн, сүүлийн жолоочийн тооцооны хуудсаар километрийн заалт автомашины километрийн заалтаас 14876 км-ээр зөрүүтэй, маршрут болон тооцооны хуудас байхгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-т “төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах”, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13-р зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **5.3.1 Байгууллагын дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын захирлын 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн А/28 тоот тушаалын хавсралт дахь ажилчдын ээлжийн амралтын амрах хоногийг алдаатай тооцсон ба үндсэн ажилтны ажилласан сард ногдох ээлжийн амралтын хоногоор тооцсон. Улмаар 43 ажилтанд 2025 оны ээлжийн амралтын хоногийг дутуу тооцож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл "Ээлжийн амралт, түүний хугацаа" гэсний 99.10-т “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэснийг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын ажилчдын ээлжийн амралтын амрах хоногийг нийт ажилласан жилээс үнэн зөв тооцож, захирлын тушаалаар баталгаажуулж, ээлжийн амралтыг олгох, ээлжийн амралтын цалин тооцох журмыг мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Театрын нээлтийн ажиллагаатай холбоотой 2023 оноос урьдчилж төлсөн зардал дансанд үлдсэн урьдчилгааг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар ажил гүйлгээг дуусгавар болгож зардлаар бүртгээгүй байна.	1	6,000.0	-	-	1	6,000.0	1	6,000.0	-	-	-	-
2	Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл дүнд биет тооллого хийхэд тухайн үлдэгдэл нь оёдол хийж дууссан жүжгийн хувцас байх тул тайлант хугацаанд уг хөрөнгийг дуусаагүй үйлдвэрлэл данснаас хасаж хөрөнгө, бараа материалын дансанд бүртгэх шаардлагатай.	1	47,135.9	-	-	1	47,135.9	1	47,135.9	-	-	-	-
<b>Дүн</b>		-	<b>53,135.9</b>	-	-	<b>2</b>	<b>53,135.9</b>	<b>2</b>	<b>53,135.9</b>	-	-	-	-

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Өмнөх оны ээлжийн амралтыг 2024 оны 7 дугаар сард эдэлсэн ба хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон 1 ажилтанд захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар ээлжийн амралтыг бүтэн хоногоор буюу 15 хоногоор тооцож, 718.6 мянган төгрөг, оёдолчинд ТҮСБ-02 ангиллаар цалинг тогтоосон боловч ТҮСБ-3 ангиллаар цалинг бодож, 769.8 мянган төгрөгийг тус тус илүү олгосон.	1	1,488.4	1	1,488.4	-	-	-	-	-	-	-	-
2	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар бий болсон төрийн болон аймаг, нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт” 704 дүгээр тогтоолоор 850 хүний суудалтай театрын шинэ барилгыг орлогод авч бүртгэлд тусгах шийдвэр ирүүлсэн боловч барилгын газрыг Сонгинохайрхан дүүргийн тамгын газраас шилжүүлэн аваагүй, түүнийг шилжүүлэн авахтай холбоотой газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны төлбөр	1	18,929,570.2	-	-	1	18,929,570.2	-	-	-	-	-	-

Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	төлөх санхүүжилтгүй гэх шалтгаанаар барилга байгууламжийг санхүүгийн тайланд бүртгэж аваагүй.												
3	Жүжгийн хувцас хэрэгслийн материалыг 7 хуулийн этгээдтэй утга агуулга ижил гэрээг байгуулан батлагдсан төсөвт өртгийг хувааж, шууд худалдан авалт хийсэн.	1	88,742.4	-	-	1	88,742.4	-	-	-	-	-	-
4	Жолоочийн тооцооны хуудас 2025 оны 1-4 сард бэлтгэсэн ба түүнээс хойш жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, шатахууны зардлын санхүүжилт байхгүй гэх боловч машинууд дээр торгуулийн хуудас сар бүр бичигдсэн, засварын зардал бүртгэсэн, төрийн өмчийн хөрөнгийг дураараа ашигладаг байдал ажиглагдсан. Сүүлийн тооцооны хуудсаар километрийн заалт 14876 км-ээр зөрүүтэй, маршрут болон тооцооны хуудас байхгүй. Саната 7, портер автомашинуудын километрийн заалт бүртгэлгүй	1	-			1	-						
5	Байгууллагын захирлын 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн А/28 тоот тушаалын хавсралт дахь ажилчдын ээлжийн амралтын амрах хоногийг алдаатай тооцсон ба үндсэн ажилтны ажилласан сард ногдох ээлжийн амралтын хоногоор тооцсон. Улмаар 43 ажилтанд 2025 оны ээлжийн амралтын хоногийг дутуу тооцож олгосон	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>19,019,801.0</b>	<b>1</b>	<b>1,488.4</b>	<b>3</b>	<b>19,018,312.6</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	

## 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1.1	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 167 мэдээллээс 165 мэдээллийг хугацаандаа, 2 мэдээллийг хугацаа хоцроож, байршуулсан.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
2	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
2.1	Хүүхэд, залуучуудын театр нь Соёлын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн загвараар холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт, тохирсон бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.	1	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	1	-
	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 103/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/284/КА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны ээлжийн амралтыг 2024 оны 07 дугаар сард авсан ба хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон Э.Алзахгүйд захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар ээлжийн амралтыг бүтэн хоногоор буюу 15 хоногоор тооцож, 718,615.54 (долоон зуун арван найман мянга зургаан зуун арван таван төгрөг тавин дөрөв) мөнгө төгрөгийг оёдолчин албан тушаалтай Д.Жавхааг ТҮСБ-02 ангиллаар цалинг тогтоосон боловч ТҮСБ-3 ангиллаар цалинг бодож 769,816.76 (долоон зуун жаран есөн мянга найман зуун арван зургаан төгрөг далан зургаа) мөнгө төгрөгийг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалин илүү олгосон нийт 1,488,432.03 (нэг сая дөрвөн зуун наян найман мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг гурав) мөнгө төгрөгийг Хүүхэд залуучуудын театрын дарга Н.Ариунболдоор нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 10090000601 дугаар дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг, нотлох баримтын хамт 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ерөнхий нягтлан бодогч (Ж.Номин) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Б.ПҮРЭВДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-60.Docx

1526200054



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 499/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/284/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд жүжгийн хувцас хэрэгслийн материалыг авахдаа утга агуулга ижил 7 гэрээг байгуулж худалдан авалт хийж, гүйцэтгэгчийг сонгохдоо шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж 88,742,380.00 (наян найман сая долоон зуун дөчин хоёр мянга гурван зуун ная) төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3 заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй, төсөвт өртөг хувааж шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд залуучуудын театрын захирал (Н.Ариунболд) ерөнхий нягтлан бодогч (Ж.Номин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Б.ПҮРЭВДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 500/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/284/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар бий болсон төрийн болон аймаг, нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт" 704 дүгээр тогтоолоор 850 хүний суудалтай 18,929,570,200.00 (арван найман тэрбум есөн зуун хорин есөн сая таван зуун далан мянга хоёр зуу) төгрөгийн театрын шинэ барилгыг орлогод авч бүртгэлд тусгах шийдвэр ирүүлсэн боловч барилгын газрыг Сонгинохайрхан дүүргийн Тамгын газраас шилжүүлэн аваагүй, түүнийг шилжүүлэн авахтай холбоотой газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны төлбөр төлөх санхүүжилтгүй гэх шалтгаанаар барилга байгууламжийг санхүүгийн тайланд бүртгэж аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйл, Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах гэсний Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэл хөтлөх гэсний 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн хуулийн заалт болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар бий болсон төрийн болон аймаг, нийслэлийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт" 704 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Театрын барилга, байгууламжийг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу данс бүртгэлд тусгаж, хөрөнгийн бүртгэлд аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд залуучуудын театрын захирал (Н.Ариунболд) ерөнхий нягтлан бодогч (Ж.Номин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Б.ПҮРЭВДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 501/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/284/НА - СТА - ТУЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхэд залуучуудын театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жолоочийн тооцооны хуудсыг 2025 оны 01 дүгээр сараас 04 дүгээр сарын хооронд хөтөлсөн ба түүнээс хойш жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, шатахууны зардлын санхүүжилт байхгүй гэх боловч машинууд дээр торгуулийн хуудас сар бүр бичигдсэн, засварын зардал бүртгэсэн, сүүлийн жолоочийн тооцооны хуудсаар километрийн заалт автомашины километрийн заалтаас 14876 км-ээр зөрүүтэй, маршрут болон тооцооны хуудас байхгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-т "төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах", мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.3-т "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жолоочийн тооцооны хуудас хөтөлдөггүй, тооцоо боддоггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхэд залуучуудын театрын захирал (Н.Ариунболд) ерөнхий нягтлан бодогч (Ж.Номин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Б.ПҮРЭВДУЛАМ